

## ЯПОН СУДЛАЛ: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

*Б.Сэржав\**

Монголчууд өнө эртнээс дэлхийн олон улс гүрэн, хүн ардын талаар мэдлэг хуримтлуулж, тэдэнтэй эрх тэгш харилцаж ирсэн түүхтэй. Тэдгээр улс орны нэг нь өвөрмөц баян түүх, соёл иргэншилтэй, хөгжлийн олон үзүүлэлтээр дэлхийд тэргүүлдэг Азийн хүчирхэг гүрэн Япон улс юм. Монгол, Япон хоёр ард түмний түүх, соёлын хэлхээ холбоо хийгээд чухам хэдий үеэс бие биеэ харилцан мэдэлцэж, улмаар хоёр оронд бие биеийн судалгааны эхлэл чухам хэдийд тавигдаж, хэрхэн өрнөн хөгжиж ирснийг тодруулах асуудал эрдэмтэд, судлаачдын анхаарал сонирхлыг татсаар байна. Юу боловч энэ асуудал түүхийн эрт үед холбогдох нь маргаангүй. Академич Ч.Далайн дурдсанчлан “Монгол, Японы түүхэн харилцаа нэн эртнээс эхэлсэн мэт боловч түүхэнд тодорхойгүй байдаг”<sup>1</sup>. Харин монгол үндэстэн сэргэн мандаж, нэгдсэн төр улс байгуулагдсан XIII зууны үе гэхэд Япон улсын тухай мэдээ, мэдээлэл баттай бий болж, Монгол гүрний гадаад бодлоготой уялдан Зүүн Ази, далайн орнууд тэр дундаа Япон улсын талаар судалгаа хийж байсан болов уу. Доктор Т.Мөнхцэцэг “Япон дахь Монгол судлал хожим XIX зууны эцэс XX зууны эхээр үүссэн гэхэд нэг л учир дутмаг бодогдоно. Японд Монголын тухай мэдээлэл, судалгааны эх аль эрт цагт тавигдсан болов уу”<sup>2</sup> хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэгвэл Монгол Улсад Японы талаархи мэдээ, мэдээлэл түүнээс ч өмнө бий болсон байх үндэстэй. Монголд Япон орны талаар хэдийд, хэр хэмжээний мэдээлэлтэй байж, ямар бодлого явуулж ирсэн талаар түүхийн сурвалжуудад цөөн боловч тусгагдсан байдаг. А.Амарын “Монголын товч түүх” (УБ, 1934), “Монгол Улсын түүх” таван боть (УБ, 2003), академич Ч.Далай “Монголын түүх (1260-1388)” (УБ, 1992), “Юань гүрний судар” (УТНС. УБ) зэрэг эх сурвалжуудаас XIII-XIV зууны үеийн Монгол-Японы харилцаа, Монголын эзэнт гүрний төрөөс Японы тухайд явуулж байсан бодлого, монголчууд япончуудын талаар ямар ойлголттой байсан зэргийг олж үзэж болох билээ.

1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо тунхагласаны дараа гадаад харилцаагаа өргөтгөх, дэлхийн хүчирхэг улсуудаар төр улсаа хүлээн зөвшөөрүүлэх алхмыг хийж, Японыг оролцуулан 9 орны элчин нарт ноот бичиг илгээн, Чин ван Ханддорж нар Петербурт гадаадын элчин, түүний дотор Японы элчинтэй уулзах оролдлого хийж, Да лам

\* Б.Сэржав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Цэрэнчимэд нарыг 1913 оны эхээр Японд илгээх үйл ажиллагааг явуулж байжээ. 1914 оны эхээр Богд эзэн хаанаас Англи, Америк, Япон, Герман, Франц зэрэг дэлхийн таван том улсын засгийн газарт захидал илгээсний дотор Япон улсын засгийн газарт илгээсэн захидалд “Монгол Улс, Япон улсын хооронд найрсаг харилцаа тогтоох, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх, өөрийн орны тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд Япон улсын тусламжийг” хүссэн байдаг. Энэ нь шинээр тусгаар тогтносон Богд хаант Монгол улсын төр, засгийн газар Япон улсыг анхааран судалж, өөрчлөгдөн хувьсч байсан олон улсын тухайн нөхцөл байдалд Монгол улсын түншилж болох гадаад тулгуурыг Япон улстай холбон үзэж байсныг гэрчлэн харуулах нэгэн чухал баримт юм. Тухайн үед тодруулбал ХХ зууны эхэн үед Япон улсын олон улсын тавцан дээрхи нөлөө өсөн нэмэгдэж, Азид явуулах бодлого нь эрс идэвхжин, түүнд Монгол улс ч хамрагдаж, улмаар Нийслэл хүрээнд худалдаачид, пүүс компанийхан, цэргийнхэн, цагчид зэрэг хэд хэдэн төрлийн япон хүмүүс амьдарч, Японы тухай мэдээ, мэдээлэл өргөжиж байжээ. Энэ тухай доктор Ц.Батбаяр “Кодама Мицүи пүүс, Хүрээнд байсан япончууд /1911-1921/” /УБ., 1993/ бүтээлдээ тодорхой дурдсан байдаг.

1910-аад оны үеэс Япон эзлэн түрэмгийлэх бодлоготой уялдан ихээхэн анхаарал тавих болсон. Тухайлбал 1908 онд орон судлалд Токиогийн Гадаад судлалын их сургуульд азийн бусад хэлнүүдийн хамт монгол хэлний анги нээж, Манжуур, Монголын талаархи улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх боловсон хүчин болох анхны гурван судлаач бэлтгэн гаргасан түүхтэй. Тухайн үед Монгол улс Японы эзлэн түрэмгийлэх бодлогод өртсөн орны хувьд олон улсын байдлын эдрээтэй нөхцөлд улс орноо батлан хамгаалах шаардлагын үүднээс япон судлалыг хойш тавин орхигдуулах үндэс байхгүй болох нь тодорхой.

Монгол Улс дэлхийн II дайнаас хойш улс орнуудтай эрх тэгш харилцах болсон тэр цагаас манай улсад япон судлал орон судлал гэсэн сонгодог утгаараа хөгжих суурь тавигдсан юм. Монгол дахь япон судлалыг авч үзэхдээ аливаа улсад орон судлалын эрэлт хэрэгцээ үүсэн гарч ирдэг нийтлэг жишиг Монгол, Японы харилцааны үе шатны хандлага чиглэл, тухайн түүхэн цаг үеийн олон улсын тавцанд Японы нөлөө хүчин зүйлтэй холбон авч үзэх хэрэгтэй болов уу.

Дайны хөлд сүйрсэн эдийн засгаа 1950-иад оны дунд үе гэхэд дайны өмнөх түвшинд бүрэн хүргэж, хөгжлийн хурдаар дэлхий дахинд хошуучилж 1956 онд НҮБ-д гишүүнээр элсэн олон улсын тавцанд байр суурь нь үлэмж дээшилж ирсэн зэргээрээ Япон улс Азийн төдийгүй дэлхийн олон улсын анхаарлыг татах болсон. Энэ бодит байдал нь хэдийгээр дипломат харилцаа тогтоогүй, дайн дажны улмаас ард олны дунд сөрөг ойлголт ихтэй байсан ч манай улсад Япон орныг сонирхон судлах, Япон

улстай холбоо харилцаа тогтоох эхлэлийг тавих сонирхол, хүсэл эрмэлзлэл аажмаар өсөн өргөжихөд нөлөөлсөн нь дамжиггүй.

1957 онд манай нэрт эрдэмтэн, зохиолч Ц.Дамдинсүрэн гуай Токиод болсон атом, устөрөгчийн бөмбөгийг эсэргүүцэх олон улсын III бага хуралд оролцжээ. Энэ үед монгол, япон эрдэмтдийн анхны уулзалт Киото, Токиогийн их сургуулиуд дээр болж, японы эрдэмтэд хоёр орны их сургуулиудыг тогтмол харилцаатай болгох, ном хэвлэл тогтмол солилцох, эрдэм шинжилгээний ажилтан нарын хооронд харилцаа тогтоох талаар саналаа илэрхийлж, санаачлага гаргасан нь хоёр орны соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны үндсийг тавих, бие биеийн тухай харилцан эерэг ойлголтыг бий болгох, хоёр орны хооронд мэдээ мэдээллийг өргөжүүлэх гэсэн чин эрмэлзлэлийн илэрхийлэл байжээ. Хоёр орны их сургуулиудын хооронд оюутан солилцож сургах тухай саналыг ч энэ үеэр Японы талаас тавьж байжээ.

Алдарт эрдэмтэн маань ингэж явсан дурсамжаа бичиж “Японы тухай тэмдэглэл” номыг Улаанбаатар хотноо 1958 онд хэвлүүлжээ. Япон оронд анх хөл тавьсан тухайгаа “Цугларсан хүмүүсийн царай зүс нь монголчууд шиг юм. Тэдний монгол хэлээр бичсэн туг далбаа, монгол царай, нэн ялангуяа элэгсэг дотноор инээмсэглэн угтаж байгаа энэ байдлыг үзээд бидэнд үл таних Япон оронд ирсэн биш Монгол нутагт ирж танил найз нараараа угтуулж байгаа юм шиг санагдаж байлаа” хэмээн манай төлөөлөгчдийг Японы ард түмэн хэрхэн элэгсэг дотноор хүлээн авсныг нь дурсан бичсэн байдаг.

“Японы тухай тэмдэглэл” дурсамж ном нь монголын олон нийтэд Япон орон, япончуудын аж байдлыг нүдэнд харагдаж, сэтгэлд хоногштол бодитой танилцуулсан анхны бүтээл юм.

Тухайн цаг үед капиталист ертөнц, түүний нэгэн гишүүн -Япон улсын талаар унших судлах боломж Зөвлөлтийн хэвлэлийн мэдээ мэдээллийн хүрээнээс хэтэрч байгаагүй ард түмний дунд шүтээн болсон эрдэмтэн зохиолч Цэндийн Дамдинсүрэнгийн өөрийн нүдээр үзэж бичсэн энэхүү ном нийтийн хүртээл болсон нь Япон орны тухай хэвшсэн сөрөг ойлголтыг өөрчлөхөд ихээхэн нөлөө үзүүлж, ард олны дунд Японы талаар сонирхох сонирхол дээшлэхэд чухал хүчин түлхэц болсон нь мэдээж.

Ийнхүү манай улсад Япон орон судлал хөгжих шинэ гарааг алдарт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн тавьж монгол, япон эрдэмтдийн хамтын ажиллагааны анхны хөтөч болсон түүхтэй.

Ц.Дамдинсүрэн гуай нарыг Японд очсоноос 2 жилийн дараа 1959 онд Улаанбаатарт болсон Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хуралд Япон улсаас Абэмацу Гэничи, Озава Шигэо, Сакамото Корэтада нарын эрдэмтэд ирж оролцсон юм.

Уг хурал дээр эрдэмтэн К.Сакамото тавьсан илтгэлдээ “Дайнаас

хойш хэдэн жилийн хугацаанд бид Монгол улстай ямарч харилцаагүй, шинэ монгол номыг үзэж чадахгүй, гагцхүү орос ном, хятад номноос монголын байдлыг мэдэж байлаа. Монгол судлаач эрдэмтэд Монгол улсад очих их хүсэлтэй байсан боловч очиж чадахгүй, тийм боломжгүй байсан нь их харамсалтай. Харин хэдэн жилийн өмнө атом устөрөгчийн зэвсгийг эсэргүүцэх олон улсын хуралд Монголоос төлөөлөгчид ирснээр бид сая харилцаа холбоо тогтоож чадлаа. Энэ удаагийн Монгол хэл бичгийн эрдэмтний их хурал биднийг их зоригжуулж байна” хэмээн дурдсан байдаг. Ингэж эх суурь нь тавигдсан хоёр талын эрдэм шинжилгээний ажлын хэлхээ холбоо, нэрт эрдэмтдийн маань хүчин зүтгэл, зориг эрмэлзлэл нь Монгол улсад япон судлал үүсч хөгжих, хоёр ард түмний харилцан ойлголцол гүнзгийрэх, улмаар хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтон, өнөөгийн түвшинд хүрч урагшлан хөгжихөд ч ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ.

ШУА-ийн харьяанд 1968 онд Ази, Африкийн хэлтэс нэртэйгээр өнөөгийн Олон улс судлалын хүрээлэн үндэс суурь нь тавигдаж, тэнд гадаад орон судлал, олон улсын харилцааны судалгаа төвлөрөх болсноор хүрээлэнгийн судалгааны ажлын гол чиглэлийн нэгэнд япон судлал орох болсон.

1972 онд Монгол улс Япон улсын хооронд дипломат харилцаа тогтож, хоёр орны харилцаа бүх салбарт урагшлан хөгжих, манай улсад япон судлалын чиглэлийн судалгаа шинжилгээний ажил өрнөн хөгжихөд онцгой ач холбогдол өгсөн юм. Дипломат харилцаа тогтоосноос хойш удалгүй хоёр орны хооронд соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулагдаж, 1974 оны 9-р сарын 23-ны өдөр “Монгол улс, Япон улсын Засгийн газрын хооронд соёлын харилцаа тогтоосон тухай ноот бичиг” солилцсон билээ. Энэхүү ноот бичигт:

- Шинжлэх ухаан техник, соёл урлаг, спортын байгууллагын төлөөлөгчид, мэргэжилтэн, аспирант, оюутан болон дээрх салбарт ажиллаж буй хүмүүсийг харилцан солилцох;

- Кино үзлэг, урлагийн тоглолт, лекц, уран бүтээл, гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг соёлын арга хэмжээг зохиох;

- Эрдэм шинжилгээний ажил хамтран хийхэд тус дөхөм үзүүлэх;

- Үзүүлэн таниулах, сонсох материал солилцох;

Эрдэм шинжилгээний ажилд зориулсан хэвлэл, мэдээллийн материал солилцох<sup>3</sup> талаар тусгажээ. Ийнхүү хоёр орны хооронд соёлын салбарт явуулах бүх чиглэлийн хамтын ажиллагааны эрх зүйн үндэс тавигдсан нь Монгол улс дахь япон судлал өрнөн хөгжихөд цоо шинэ үеийг нээсэн түүхэн үйл явдал болсон билээ. Уг хэлэлцээрийн дагуу МУИС-д япон хэлний багш, япон оюутан судлаачдыг хүлээн авдаг, мөн манай талаас монгол хэлний багш нарыг Японы Токиогийн Гадаад

судлалын их сургууль, Осакагийн Гадаад судлалын их сургуулиудад урилгаар ажиллуулдаг, монгол оюутан, мэргэжил дээшлүүлэгчдийг Японд цөөн тоогоор боловч суралцуулдаг болсон юм.

Монгол улсын их сургуульд 1975 оноос япон хэлний сургалт явуулж эхэлжээ. ЗХУ-ын их, дээд сургуулиудад япон хэлтэй боловсон хүчин бэлтгэхийн зэрэгцээ үндэсний их сургуульд япон хэлний сургалт явуулдаг, улмаар Япон улсад хэлний мэргэжил дээшлүүлэгч, судлаач оюутан суралцуулдаг болсон нь япон хэлтэй боловсон хүчин, япон судлаачдыг бэлтгэн гаргах, тэдний мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд ач холбогдолоо өгсөн билээ.

1970-80-аад оны үед япон судлалын ажил ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Түүхийн хүрээлэн зэрэгт төвлөрөх хандлагатай байв. Эдгээр хүрээлэнгүүдэд анхааран судалж байсан гол сэдвүүдийн нэг нь Япон улс дахь монгол судлал байлаа. Япон улс монгол судлалыг ХХ зууны эхэн үеэс түүх, улс төр, нийгэм, эдийн засаг, хэл, соёл, утга зохиол, боловсрол гэх мэт олон салбарт идэвхжүүлж, монгол судлалаар дэлхийд тэргүүлэх байранд гарч ирсэн билээ. Япон дахь монгол судлалын ололт амжилт нь манай улсын япон судлалд ахиц гарахад ч тодорхой нөлөө үзүүлсэн юм. Эхний үед манай судлаачид Япон улсад хийгдэж буй монгол судлалын ажил, японы эрдэмтдийн туурвисан манай улсын холбогдолтой гол гол бүтээлүүдийг судлан танилцуулах ажлыг хийж “Хятад, Япон дахь монгол судлалын тоймоос” хамтын бүтээл /УБ. 1988/ хэвлэгдэн гарсан нь дээрх судалгааны анхны үр дүн болсон юм.

“Хятад, Япон дахь монгол судлалын тоймоос” эмхэтгэл нь хятад, японы эрдэмтдийн судалгаа шинжилгээний ажлыг бүрэн хамруулж чадаагүй ч эдгээр орнуудын монгол судлалын ололт амжилтыг тодруулан мэдэх, судлах ажлын шаардлагад нийцэж, хэл орчуулгын бэрхшээлийн улмаас хэрэгжихэд хүндрэлтэй байсан тухайн үеийн эрэлт хэрэгцээг хангахад тус дөхөмтэй шинэлэг бүтээл болж чадсан гэж үзэх үндэстэй.

Дээрх сэдвээр сүүлийн үед доктор Т.Мөнхцэцэг “Япон дахь Монголын түүхийн судалгаа /1900-1995/” /УБ. 2000/ нэгэн сэдэвт зохиол туурвиж нийтийн хүртээл болголоо. Энэ бүтээл нь дэлхийн монгол судлалын том төв Япон улс дахь Монголын түүх судлалыг археологи, эртний улс, дундад зуун, шинэ түүхээр туурвисан бүтээлүүдээр төлөөлүүлэн судалж, үнэлэлт дүгнэлт өгсөн шинэ бүтээл болсон юм. Энэ нэг сэдэвт зохиолд Японд монголын мэдээлэл судалгааны эх хэдийд тавигдсан, Хубилай хаан хэд хэдэн онд Япон руу элч илгээсэн, элчийн бүрэлдэхүүн, удаа дараагийн захидлын агуулга, Солонгосын вангаас Японы хаанд явуулсан захидал, япончууд Монголтой харилцах харилцаандаа баримталсан байр суурь, монголчуудын хоёр удаагийн

довтолгоон японы нийгэмд хэрхэн нөлөөлсөн, Монголын түүхэнд холбогдох ямар сурвалж бичиг байдаг зэргийг тэндэхийн сурвалж хийгээд түүхчдийн бүтээлд түшиглэн судалж, шинэлэг мэдээ хэрэглэгдэхүүнийг судалгааны эргэлтэнд оруулсан билээ.

1980-аад оны сүүлчээр дэлхий дахины олон улсын амьдралд гарсан үндсэн эргэлт, Монгол улсад өрнөсөн ардчилал шинэчлэлт нь манай улсын гадаад харилцааг үндсээр нь өөрчилж, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлого хэрэгжиж эхэлснээр Монгол-Японы харилцаа шинэ үе шатанд дэвшин, эрс идэвхжиж үсрэнгүй хурдацтай хөгжиж эхэлсэн юм. Энэ шинэ нөхцлийн гараатай хөл нийлүүлэн манай улс дахь япон судлалын ажлын цар хүрээ урьд өмнөхөөс өргөжин тэлж, судалгааны ажил Япон дахь монгол судлалын зэрэгцээ Монгол, Японы харилцаа, Японы хөгжлийн туршлага, Япон орон судлалын чиглэлд түлхүү хандах боллоо. Хүрээлэнгийн залуу судлаачдын хамтын бүтээл “Япон орон, япончууд” /УБ. 1990 / хэмээх жижиг товхимол 1990 онд хэвлэгдлээ.

Энэ товхимол нь манай улсын нийгмийн өөрчлөлтийн шинэ цаг үед Япон улс, Японы ард түмний түүх, соёл иргэншил, өнөөгийн хөгжлийн талаар өөрийн орны уншигчдад бодит мэдээллийг өгч чадсан танин мэдэхүйн зохих ач холбогдолтой ажил болсон.

1989 онд эрдэмтэд, судлаачдын санаачлагаар ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн дэргэд Япон судлалын төв анх байгуулагдаж, мөн оноос Монголын радио япон хэлээр нэвтрүүлэг явуулан, япон хэлийг сурах олон нийтийн идэвх сонирхол эрс дээшилж, ерөнхий боловсролын зарим дунд сургуульд япон хэл зааж эхэлсэн зэрэг нь Япон орон, японы ард түмний талаар танин мэдэх гэсэн эрмэлзлэлийг улам гүнзгийрүүлж, хоёр ард түмний харилцан ойлголцол, хамтын ажиллагаа бүх талаар тэлэн өргөжихөд тус дөхөм үзүүлэх гэсэн хүчин чармайлтын нэг хэсэг болсон юм.

90-ээд оноос Монгол-Японы харилцааны судалгаанд нэлээд ахиц гарсан гэж хэлж болох биз ээ. Зүүн Хойт Ази судлалын төвийн эрдэмтэд судлаачдын бичиж нийтлүүлсэн “Монгол-Японы харилцаа: эрт, эдүгээ” /УБ. 1998/ эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл нь манай улсад Монгол-Японы харилцааны сэдвийг дагнан авч үзсэн анхны хамтын бүтээл бөгөөд хоёр орны харилцааны түүх, орчин үеийн байдал, хамтын ажиллагааны төлөв, цаашдын чиг хандлагыг тусгасан өгүүллүүд орсон юм.

Түүхийн шинжлэх ухааны доктор Ц.Батбаяр “Монгол ба Япон: ХХ зууны эхэн хагаст” /УБ. 1998/ хэмээх эрдэм шинжилгээний дорвитой бүтээл туурвиж, нийтийн хүртээл болголоо. Доктор Ц.Батбаяр судалгаандаа ХХ зууны эхэн хагасын Монгол-Япон-Зөвлөлт-Хятадын хоорондын харилцааны хувьсал өөрчлөлт, ээдрээ төвөгтэй мөчүүдийг задлан шинжилж, Монгол улсын тусгаар тогтнолын

асуудалд Монгол-Японы харилцаа, Японы хүчин зүйл хэрхэн нөлөөлж ирснийг Монгол, Орос, Япон, Хятад зэрэг орны архивын хэрэглэгдэхүүнд тулгуурлан үнэлэлт дүгнэлт өгснөөрөө энэ бүтээл Монгол-Японы харилцааны судлал төдийгүй Монголын түүх судлалд жинтэй хувь нэмэр оруулсан цоо шинэ бүтээл болсон билээ.

Монгол улс, Япон улсын харилцааны ХХ зууны сүүл хагасийн түүхийг судалж Б.Сэржав “Монгол-Японы харилцаа: ХХ зууны сүүлийн хагаст” /УБ. 2003/ нэгэн сэдэвт зохиол бичжээ. Монгол, Японы хооронд ХХ зууны сүүлийн хагаст өрнөж ирсэн харилцааны түүхэн замналыг цаг үеийн хандлага, олон улсын харилцааны нөхцөл байдал, хүчин зүйлстэй уялдуулан авч үзсэн энэхүү нэгэн сэдэвт зохиол нь дипломат харилцаа тогтоох, шинэ тулгар харилцааг өргөтгөн эрчимжүүлэхийн төлөө хоёр талаас ихээхэн хүчин чармайлт гаргаж, ХХ зууны 90-ээд оноос цоо шинэ шатанд дэвшүүлэн, улмаар ХХI зуунд “иж бүрэн түншлэлийн” түвшинд хүргэж хөгжүүлэхээр зорьж буй түүхэн үйл явцыг холбогдох сурвалж бичиг, судалгааны зохиол, архивын хэрэглэгдэхүүн, албан ёсны баримт бичгүүдэд тулгуурлан үнэлэлт дүгнэлт өгч, хоёр талын харилцааны үнэт зүйл, сургамж, хөгжлийн чиг хандлага, хэтийн төлвийг тодруулахыг зорьсон шинэлэг бүтээл боллоо.

“Монгол, Японы харилцаа: эрт эдүгээ” /УБ. 2001/ хамтын бүтээлийг манай нэртэй түүхч эрдэмтэд, дипломатчид хамтран бичиж, Монгол, Японы харилцааг дэмжих /Түншийн холбоо/ нийгэмлэгээс эрхлэн хэвлүүлжээ. Уг бүтээл нь Монгол, Японы харилцааны түүхийг дундад эртний үеэс орчин үеийг хамруулан, хоёр талын харилцааны ойрын ирээдүйн болон алс хэтийн хандлагыг олон талаас нь нээн харуулахыг зорьсон өвөрмөц бүтээл болсон юм.

Монгол, Японы харилцааны түүхийн талаар хэвлэгдсэн сүүлийн үеийн шинэ бүтээл гэвэл доктор Т.Мөнхцэцэгийн бичиж олны хүртээл болгосон “XIII- XIV зууны үеийн Монгол Японы харилцаа” /УБ. 2005/ хэмээх нэгэн сэдэвт зохиол юм.

Энэ зохиолд Монгол, Японы харилцаа анхлан тогтсон тухай, мөн Монгол эзэнт гүрний төрөөс Япон улсыг эрхшээлдээ оруулах талаар явуулсан бодлого, ажиллагаа, Японд илгээсэн элч нар, тэдний хувь заяа, Монголын Юан улстай харилцахад баримталсан Японы байр суурь, Японы талаархи Юаны бодлого 1280-аад оноос хэрхэн өөрчлөгдсөн зэргийг нарийвчлан үзэж шинэ санаа, дүгнэлт дэвшүүлсэн байна. Энэ бүтээл нь Монголын түүхийн зангилаа асуудлын нэг болох XIII-XIV зууны үеийн Монгол, Японы харилцааны түүхийн судалгаанд хувь нэмэр оруулсан бүтээл боллоо.

1990-ээд оноос Монгол улсад өрнөсөн ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явцыг тууштай дэмжиж, олон талын тусламж дэмжлэгийг тогтвортой үргэлжлүүлж ирсэн улс бол Япон билээ.

Шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг гэтлэн давахад Япон улсын зүгээс үзүүлж ирсэн эдийн засгийн хамтын ажиллагаа, нийгмийн амьдралын бүх салбарын олон талт тусламж дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт бусад орныхоос илүү шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. Тиймээс ч манай улсад сүүлийн үед энэ талын судалгаа эхлэн явагдаж, эрдэм шинжилгээний товхимол, хамтын бүтээл, судалгааны өгүүллүүд нийтлэгдэн гарч байна. ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэнгийн Япон судлалын секторын эрдэмтэд судлаачид бичиж, доктор Ц.Баатар редакторлан “Японы хөрөнгө оруулалт, зээл тусламж, түүний үр ашиг” /УБ. 2004/ хамтын бүтээлийг уншигчдын хүртээл болголоо. Хандивлагч орнуудаас манай улсад үзүүлж буй зээл, тусламжийн бараг 70 орчим хувийг дангаараа гаргаж байгаа Япон улсын зээл, тусламж, хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, түүний ашиглалт, үр өгөөжийн талаар дагнасан судалгаа хийж, түүний үр дүнг нийтлүүлсэн бүтээл урьд өмнө гарч байгаагүй юм.

Энэхүү хамтын бүтээлд дээрхи асуудлыг цогц байдлаар авч үзэж, түүний ашиглалт, үр дүнг задлан шинжилж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид олон талт хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж эрчимжүүлэх арга зам, Монголын хөрөнгө оруулалтын орчин, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, эерэг сөрөг тал зэрэг асуудлыг хөндөн судлах оролдлого хийснээрээ шинэлэг талтай, тодорхой асуудлыг дэвшүүлэн тавьсан судалгааны ач холбогдол бүхий бүтээл болсон юм.

Монгол, Японы эдийн засгийн салбарын хамтын ажиллагааны үүсэл, өнөөгийн хөгжлийн талаар сүүлийн үед олны хүртээл болсон бүтээлийн нэг нь Д.Жамбалдорж, Д.Галсандорж нарын нийтлүүлсэн “Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагааны үүсэл, хөгжил, өнөөгийн байдал, хэтийн төлөв” /УБ. 2005 он/ эмхэтгэл юм. Энэхүү эмхэтгэлд Монгол, Японы харилцааг хэвийн болгоход түлхэц үзүүлсэн гол үйл явдлууд, дипломат харилцаа тогтоосны дараахи эдийн засгийн хамтын ажиллагааны талаархи яриа хэлэлцээ, түүний хэрэгжилт, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, манай улсын эдийн засгийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмэр, хамтын ажиллагааны хэтийн төлвийг хамруулан авч үзсэн байна. Мөн Монгол, Японы харилцаа хамтын ажиллагааг үүсгэн хөгжүүлэхэд биечлэн оролцож явсан хүмүүсийн дурсамжийг оруулж нийтэлжээ.

Академич Т.Намжим “Япон орон тоймлон харвал” /УБ. 1999/ судалгааны зохиолдоо Япон орон, японы ард түмний түүх, соёл, өнөөгийн хөгжлийн талаар монгол уншигч нарт танилцуулж, “Япон, Монголын харилцаа” хэмээх бүлэгт Япон-Монголын харилцааны түүх, орчин үеийн байдлын талаар авч үзжээ.

Эдгээр нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээлүүдээс гадна Монгол, Японы харилцааны асуудлаар олон тооны судалгааны өгүүлэл



нийтлэгдэн уншигчдын хүртээл болсоор ирсний заримаас энд дурдвал, Ч.Далай “Монгол-Японы түүхэн харилцааны зарим асуудалд: Юан гүрний цэрэг Японыг довтолсон тухай” /”Монгол-Японы харилцаа: эрт эдүгээ” УБ., 1998/, “Монгол, Японы дундад эртний үеийн түүхэн харилцааны тоймоос”, /”Монгол Японы харилцаа: эрт эдүгээ”, Интерпресс хэвлэлийн газар, УБ., 2001/, А.Буянтөгс “Монгол, Японы эдийн засгийн харилцаа” /”Зүүн хойт Ази судлал” сэтгүүл, 1992, №1/, “Монгол, Японы худалдаа эдийн засгийн харилцаа” /”Олон улс судлал” сэтгүүл, 2002, №1/, С.Дамбадаржаа “Өгөөжтэй 20 жил” /”Дорно өрнө” сэтгүүл, 1992, №2/, Н.Дангаасүрэн “Японы хөгжлийн туршлага” /”Зүүн хойт Ази судлал” сэтгүүл, 1992, №1/, Т.Мөнхцэцэг “Хубилай хааны хоёр довтолгооны тухайд” /”Түүхийн судлал”, боть 29, УБ., 1995/, “Монгол, Японы харилцааны түүхэнд холбогдох нэгэн сурвалжийн тухай өгүүлэх нь”, /”Монгол Японы харилцаа: эрт эдүгээ”, “Эрүүл мэнд хэвлэлийн газар”, УБ., 1998/, “Хубилай хааны 1275 онд илгээсэн элчийг тодруулах нь”, /”Түүхийн судлал”, УБ., 2004/, У.Загдцэсэм “Япон улсын засгийн газрын хөгжлийн тусламж, түүний зориулалт, ач холбогдол” /”Олон улс судлал” сэтгүүл, 2002, №1/, Т.Намжим “Монгол, Японы харилцааны идэвхжил ба учир холбогдол” /”Олон улс судлал” сэтгүүл, 2002, №1/, О.Оюунгэрэл “Монгол, Японы харилцаа үүсч хөгжсөн нь” /”Дорнодахины судлалын асуудал” сэтгүүл, 1988, №2/, “Монгол, Японы худалдаа эдийн засгийн харилцаа” /”Дорнодахины судлалын асуудал” сэтгүүл, 1983, №2/, Б.Сэржав “Монгол, Японы харилцаа өнөөгийн шатанд” /”Монгол, Японы харилцаа: эрт, эдүгээ” УБ., 1998/, “Монгол Улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтсон нь”, /”Олон улс судлал” 2001, №2/, “Монгол, Японы харилцаа шинэ зууны гараанд” /”Олон улс судлал” сэтгүүл, 2002, №1/, “Монгол, Японы хамтын ажиллагаа: Японы хөрөнгө оруулалт”, /”Олон улс судлал” сэтгүүл, 2005, №4/, Ж.Уянга “Шилжилтийн үеийн Монгол, Японы харилцаа” /”Олон улс судлал” сэтгүүл, 2002, №2/, Л.Хайсандай “Монгол, Японы харилцаа: эерэг хандлага, өөдрөг үйл явц” /”Зүүн хойт Ази судлал” сэтгүүл, 1996, №1/ гэх зэрэг нэлээд өгүүлэл бичигдэн нийтлэгдэж хоёр орны харилцааны асуудлыг өргөнөөр авч үзсээр байна.

Манай улс дахь япон судлалын нэгэн чиглэл нь япон хэл судлал, монгол япон хэлний харьцуулсан судалгаа юм. Энэ ажлыг Монгол улсын Их сургууль, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд голлон явуулж ирлээ. Энэ хугацаанд Г.Жамбалсүрэн “Очерки сопоставительной грамматики японского и монгольского языков” М., 1978, диссертаци зохиол бичиж эрдмийн зэрэг хамгаалжээ. Мөн С.Долгор “Япон, Монгол хэлний дууриах үгийн харьцуулал” УБ., 2005 диссертаци зохиол бичиж докторын зэрэг хамгаалав. Эдгээр ажлууд нь алтай язгуурын төрөл хэл болох монгол, япон хэлний талаар урьд хийгдсэн судалгаанд тулгуурлан хоёр хэлний

нийтлэг хийгээд өвөрмөц онцлогийг тогтоон тодотгосноороо япон, монгол хэлний сургалт судалгааны ажил болон орчуулгын дүйцлийн асуудалд онолын хийгээд хэрэглээний ач холбогдол бүхий бүтээлүүд болсон юм.

1990 оноос хойших хоёр орны харилцааны эрс идэвхжил нь манай улс дахь япон судлал, япон хэлний сургалтын ажлын хязгаарлагдмал хүрээг үндсээр нь өөрчилж, монголын олон нийт ялангуяа хүүхэд залуусын дунд япон орныг сонирхон судлах, япон хэлийг суралцах идэвхи санаачилга огцом түгэн дэлгэрч, япон хэлний сургалт явуулах их дээд сургууль, дунд сургуулийн тоо олшрон, энэ хандлага өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа билээ. 2003 оны байдлаар манай улсад япон хэл суралцагсдын тоо 10 гаруй мянга болж, нийт 67 их, дээд, дунд сургууль япон хэлний сургалт явуулж, 199 багш ажиллан<sup>4</sup>, япон хэлний багш, орчуулагч, хэл судлаач, аялал жуулчлалын мэрэгжилтэн зэрэг олон салбарын боловсон хүчнийг бэлтгэн гаргах боллоо.

Япон улсад суралцаж буй монгол оюутны тоо жилээс жилд улам өсч ирлээ. 1990 онд манай улсаас нийтдээ 15 оюутан суралцаж байсан бол 2005 онд 924 оюутан суралцаж байна<sup>5</sup>. Япон хэл, соёл судлалын чиглэлээр жил бүр тодорхой тооны оюутныг Япон улсад хүлээн авч суралцуулж байгаа нь манай улс дахь япон судлалын боловсон хүчин өсч бойжиход чухал нөлөөтэй тусламж дэмжлэг юм. 2005 оны байдлаар хүн амын 10 мянган хүн тутамд ногдох Японд суралцагсдын тоогоор манай улс тэргүүн байранд орох боллоо.

Монголын ард түмэнд Япон улс, Японы ард түмний түүх, соёл, өнөөгийн бодит байдлыг танилцуулах, японы талаар сонирхогч, судлагч нарыг дэмжин туслах чиглэлээр Монголын япон хэлний багш нарын холбоо, Японд сургууль төгсөгчдийн ЖУГАМО нийгэмлэг, Монгол дахь Японы соёл, утга зохиолын төв зэрэг олон нийтийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж ирлээ. Тухайлбал Монгол дахь Японы соёл, утга зохиолын төв нь “Ниппон ньус” сонинг тогтмол нийтэлж, японы уран зохиолоос 30 гаруй бүтээл монгол хэлээр орчуулж, уншигчдын хүртээл болгожээ. Кавабата Ясунари, Нацумэ Соосэки, Шиба Рёотаро, Фүкүзава Юкичи, Оэ Кэнзабүро, Кайко Такэши зэрэг дэлхийн хэмжээнд алдартай зохиолчдын бүтээлүүдийг төрөлх хэлээрээ унших бололцоог ард түмэндээ олгосон нь японы ард түмний оюуны үнэт эрдэнэстэй танилцаж, тэдний түүх, нийгэм, соёл, зан заншил, сэтгэлгээг ойлгоход ихээхэн ач холбогдолтой юм.

Манай улс дахь Япон судлалын түүхэн тоймыг хураангуйлан авч үзээд, өнөөгийн хүрсэн түвшинг эргэж харахад япон судлал манайд зөвхөн эхний шатандаа, хоёр талын харилцааг судлах хүрээнээс хальж амжаагүй явна гэж үзэж болохоор байна.

Глобалчлалын үед өнөөгийн эринд Монгол Улсын цаашдын хөгжлийн асуудал гадаад хүчин зүйлтэй нягт холбоотой гэдэгтэй маргах

хүн байхгүй биз. Өнгөрсөн зууны 90-ээд оноос хойш Япон улс Японы ард түмэн манай улсын хамгийн тууштай том дэмжигч түшиг байсаар ирлээ. Цаашид ч иж бүрэн түншлэлийн харилцаатай хамгийн найдвартай түнш орон бол Япон улс байх нь дамжиггүй. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хөгжлийн шийдвэрлэхүйц томоохон гадаад хүчин зүйлийн нэг нь Японы хүчин зүйл гэж үзэх үндэслэл бүрэн бий. Чухам улс орны хөгжлийн энэхүү эрх ашгийн үүднээс япон судлалыг өнөөгийн шатнаас гүнзгийрүүлж жинхэнэ орон судлалын утгаар нь урагшлуулан хөгжүүлэх Монголын Япон судлаачдын зорилт бидний өмнө тулгарч байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи япон судлалд анхаарал тавьж 1999 оноос Олон улс судлалын хүрээлэнд энэ ажлыг гүйцэтгэх шинжилгээ судалгааны бие даасан нэгж болох Япон судлалын секторыг шинээр зохион байгуулж ажиллуулах болсон билээ. Энэ нь тус хүрээлэнгийн япон судлалын уламжлалыг бататгаж, уг судалгааг өргөтгөн урагш ахиулахад чиглэсэн чухал арга хэмжээ болсон юм.

Цаашид Японы ард түмний соёл, зан заншил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түүхээс суралцаж, ард түмэндээ өргөн ойлголт өгөх, манай улсын цаашдын хөгжилд тусган авч үр өгөөж өгөхүйц ашигтай туршлагыг судлах, хоёр орны харилцааг ард түмний өргөн ойлголцлын үндсэн дээр хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах нь япон судлалын ажлын өнөөгийн гол зорилт болж байна. Өөрөөр хэлбэл Японы хөгжлийн туршлага сургамжаас бүтээлчээр суралцах, улс орныхоо хөгжлийг түргэтгэхэд түүнийг оновчтойгоор ашиглах, тусламж дэмжлэг авах зэрэг хөгжил дэвшлийн амин чухал зангилаа асуудлуудтай япон судлал салшгүй нягт уялдаа холбоотой. Тухайлан дайнаас хойших Японы улс төр, эдийн засгийн бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүтцийн өөрчлөлт, хөгжлийн замд тохиолдсон саад бэрхшээл, өндөр хөгжлийн эерэг сөрөг үр дагавар, өнөөгийн эдийн засгийн байдал, энэ бүхнийг Монгол Улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тал бүрээс нь ул үндэстэй улируулан нухацтай судлах явдал япон судлаачдын өмнө тулгарч буйг дахин тэмдэглэн хэлэх нь зүйд нийцэх биз ээ.

## ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Ч.Далай. Монгол, Японы дундад эртний үеийн түүхэн харилцааны тоймоос. “Монгол, Японы харилцаа: эрт, эдүгээ” УБ. 2001. х.23.
2. Т.Мөнхцэцэг. “Япон дахь Монголын түүхийн судалгаа /1900-1995/”, УБ. 2000, х.22.
3. Монгол Улсын Гадаад харилцааны яамны архив,. Ф.59, 3/1345
4. Survery Report on Japanese-Language Eduvation Abroad 2003. Japan Foundation 2004. p.16-17
5. Нихонго киоикү житэн /Япон хэлний сургалтын толь бичиг/ Тайшюүкан шётэн 2005, х.1049